

ЕРТӨНЦИЙГ ҮЗЭХ БӨӨГИЙН ШАШНЫ БА СИНЕРГЕТИК ҮЗЛИЙН ТАЛААРХ ЗАРИМ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Г.Цэрэн, Х.Оюунбаатар

ШУТИС, Хүмүүнлэгийн ухааны сургууль

Цагдаагийн академи

Түлхүүр үгс: шашин, шинжлэх ухаан, бөөгийн шашин, бөө, удган, онгод, сүнс, харанхуйн орон, харсан тэнгэр, мэдээлэл, аттрактор, Ороны Нэгдсэн Онол.

Аннотация

Все, что новое, хорошо забытое старое такое крылатое выражение наверно есть во всех языка мира. В нынешнем открытом информационном технологическом обществе, люди свободно обмениваются опытом, знаниями и другими ценностями научного, технологического и другого характера. Философские, культурно-антропологические интерпретация и выводы вытекающие от новых достижения естественнонаучных открытии, и развития hi-information technology, нейролингвистических программировании, парапсихологических исследований опирающихся на синергетических методологических принципах очень сильно напоминают образы и концептуальные представления о иерархическом и параллельном мирах монголов сохранены в различных жанрах устного народного творчества. Такое уникальное, очень интересное положение дела привели нас к некоторым размышлениям и мы решили поделиться с вами обсудить эта очень интересные, актуальные темы.

Үндсэн хэсэг

Монголчууд бид эрс шинэчлэлийн үед амьдарч байна. Энэ шинэчлэл хүн бүхний үзэл бодол, итгэл үнэмшил, эрх ашиг, хүсэл сонирхол гэх зэрэг амьдралын нарийн нийлмэл үйл явцын бүх талуудтай холбоотой олон асуудлыг ямар нэг байдлаар хөндөж байгаа учраас бид юуг, яагаад, яаж өөрчилж, шинэчилж байна вэ? Туйлын олонхид хэвшмэл зүйл болчихсон үзэл санаа хийгээд хүмүүсийн хоорондын харилцааны хэм хэмжээний шинэчлэлийн үйл явц юунд хүргэх вэ? Бид шинэчлэлээс ямар үр дүн

хүлээж байна вэ? гэх зэрэг асуудлууд бид бүхний сэтгэлийг зовоож, оюун ухааныг эзэмдэж байна. Дээрх асуудлуудад шашны янз бүрийн сургаал, номлол өөр өөрийн үзэл суртлын үүднээс, байгалийн, нийгмийн, техник, технологийн, хүмүүнлэгийн шинжлэх ухааны янз бүрийн салбарын төлөөлөгчид өөр өөрсдийн онол, арга зүйн байр сууринаас хариулт өгөх оролдлогууд хийцгээж байна. Үүний үр дүнд өнөөгийн Монгол хүн, Монголын нийгмийн амьдралын хөгжил, өөрчлөлтийн үйл явцын тухай олон өнгө аястай, нэлээд тохиолдолд бие биеэ үгүйсгэсэн шинжтэй үзэл баримтлалууд үүсэн буй болж, зэрэгцэн оршиж байна.

Бөөгийн шашин оршин байгаа бүх юмс амьтай, амь даагч зүйл нь эзэнтэй гэж үздэг. Амь нь юмсын мэдээлэлжсэн байдлын(информационность) түвшнийг илэрхийлэх үзүүлэлтийн нэг мөн. Хүн бол орчлон хорвоогийн гайхамшиг мөн бөгөөд оройд нь ч гялалзаж явдаг, ёроолд нь ч бараантан хэвтдэг бие, сэтгэл, оюун гурваас бүрдсэн амьтан юм. Хүн өөрийгөө танин мэдэх, өөрөө өөрийнхөө уг чанараас урган гарсан авъяас билгээрээ өөрөө гэгээрэн боловсронгуй болох чадавхи бүхий өөрөө хөгждөг(саморазвивающий) амьтан юм. Өөрөөр хэлбэл, хүн мэдээлэл байнга хүлээн авч цацруулахын зэрэгцээ хуримтлуулан боловсруулж, улмаар цэвэр мэдээлэл буюу сүнс санаа төлөвтэйгээр оршиход хүрдэг амьтан мөн. *"Биеэ мэдэж хүн болно, бэлчээрээ мэдэж мал болно"* гэсэн монгол зүйр цэцэн үг, *"өөрөө өөрийгөө танин мэд"* гэсэн Сократын сургаал хоёр яв цав адилхан утга санаа, ач холбогдолтой.

Нэн эртнээс хүн өөрийгөө танин мэдэхийг хичээн оролдож ирсэн ба өнөө үед хүний тухай хамгийн гүн гүнзгий, олон талтай мэдлэг чиг баримжаа, нэр хүнд, нөлөөнөөс үл хамааран янз бүрийн философийн хийгээд шашны сургаалын дотор хуримтлагдан хадгалагдаж байна. Хүн төрөхтөний, хүн төрөлхтний гэсэн хоёр үг хэллэгийн сонголтын асуудалд хэт гэнэн хандаж болохгүй. Хүн төрөлхөтний оюуны түүхэнд хувь нэмрээ оруулсан агуу их сэтгэгчдийг хүн өөрөө өөрийгөө танин мэдэхэд оруулсан хувь нэмрээр нь эрэмбэлэн зэрэглэж рейтингийг нь тогтоож болно. Хүн төрхтэй боловч хөгжил дэвшилд өчүүхэн ч хувь нэмэр оруулаагүй төдийгүй ухралт буцалт, доройтол мөхөлд л гайхамшигтай үүрэг гүйцэтгэсэн адгууснаас дор гэж хэлж болох амьтад хичнээн олон билээ?!

Эрдэмтэн О.Пүрэв "Монгол бөөгийн шашин" номондоо "Монгол бөө судлалын нэг чухал хэсэг нь байгалийн нэгэн төрөл амьтад болох хүмүүсийн

зүгээс лус, савдаг, өвөг дээдсийнхээ сүнстэй нөхцөж харьцах үйлийн үрийн тухай, бөө хүний сүнс болох онгодоос чоно, баавгай, хэрээ, шаазгай зэрэг ан амьтан, шувууны сэтгэхүйд нөлөөлдөг хүчин зүйлийн тухай асуудлууд юм”¹ хэмээн бичжээ. Энэ нь Монголын бөөгийн шашин нь хүн өөрийн хүрээлэн байгаа орчинтойгоо харьцах, тэгэхдээ хамгийн гол нь онгод хэмээн нэрлэгдэх бөө хүмүүсийн сүнстэй харилцах тухай асуудал мөн гэсэн хэрэг. Лус савдаг бол газар дэлхийтэй харилцах, харин онгод бол дээд тэнгэртэй харилцахтай холбоотой ойлголтууд юм. Бөөгийн шашинд, *хан тэнгэр, хатан дэлхий газар усны эзэд* гэсэн ойлголтуудаас гадна *сүнсний* тухай асуудал чухал байр суурь эзэлдэг. Шинэлэг философийн онол, аргазүйн багцалмал үзэл баримтлалыг удирдлага болгон хийж буй Монгол бөөгийн шашны цэгцтэй иж бүрэн судалгаа нь монголчуудын сэтгэлгээний уламжлалт соёлын өв санд тулгуурлан Хүн судлалын шинжлэх ухааныг хөгжлийн шинэ үе шатанд гаргах боломжийг олгоно гэж үзэж байна.

Шинжлэх ухааны сэтгэлгээ өнөөдөр микро болон макро ертөнцийг танин мэдэх талаар томоохон алхмууд хийж, асар их үр дүнд хүрээд байгаа боловч өөрийгөө танин мэдэх талаар туйлын хангалтгүй гэж хэлж болох нэн дуу түвшинд байна. XIX зуун байгалийн шинжлэх ухаан, техникийн хөгжлийн зуун байсан бол XXI зуун бионанотехнологийн ба хүмүүнлэгийн шинжлэх ухааны эрин болно. Хүн судлалын шинжлэхүй ухаан(антропологи) түүхэн хөгжлийн явцдаа физик антропологи, биологийн антропологи, нийгмийн антропологи, соёлын антропологи, хуулийн антропологи, боловсролын антропологи, философийн антропологи гэх зэрэг хэлбэр, хэв маягтай байсан, сүүлийн хэдэн жилд энергийн антропологи үүсэн хөгжиж байна. Синергетик онол, аргазүйг удирдлага болгосон Монгол бөөгийн шашны судлал нь хүн судлалын шинжлэх ухааны шинэ үе шат болох мэдээллийн буюу мэдээлэл судлалын (информациологический) антропологи үүсэн хөгжихөд хүргэнэ.

Бүх амьтад сүнстэй. Хүн ч мөн адил. Хүний тэнгэр сүнс устдаггүй, мөнх оршино хэмээн бөөгийн шашин үздэг. Цаг хугацаа-орон зайд устаж үгүй болохгүй учраас тэнгэр сүнс үүсээгүй болох нь зайлшгүй. Бөөгийн дуудлагад “*үүлэн хорвоод төрөөгүй, үхэх сэхэхийг үзээгүй*” гэж гардаг нь үүний нотолгоо юм². Буддын сургаалд хүн, амьтад нас барсны дараа сүнс нь

¹ Пүрэв О. Монгол бөөгийн шашин. УБ., 1998. Оршил.

² Сүхбат Ш. Монгол нүүдэлчин ардын шашин шүтлэгийн зан үйл. УБ., 2005. 34 дэх тал.

эргэж ямар нэгэн хүн, эсвэл амьтан болж төрдөг, улмаар ийм тасралтгүй эргэлтийг сансрын хүрд, зовлонгийн хүрдэн хэмээн нэрлэдэг. Харин бөөгийн шашинд сүнс эргэн төрөх асуудлаас илүүтэйгээр хүний ертөнцөөс бөө, удган, заарин нарын сүнстэй харилцах, улмаар онгодоор дамжуулан бусад хүн болоод амьтад, байгальтай харилцах, түүнд нөлөөлөх, түүний зааврыг сонсох, дамжуулах зэрэг үйлийг чухалчилдаг¹ ажээ. Өөрөөр хэлбэл, нэг сүнс нөгөө сүнстэй харилцах үйл, түүний олон тал, өвөрмөц онцлогтой зан үйлийг янз бүрээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа бол бөөгийн шашны үндсэн агуулга гэж хэлж болох бөгөөд информაციологическая антропологи(мэдээлэл судлалын антропологи) орчин үеийн шинжлэх ухааны нэг нэгдмэл философийн ба шашны нэг нэгдмэл философийн уулзвар, огтлолцол дээр шинэ хэв маягтайгаар хөгжихөд хүргэнэ.

Монголын бөөгийн шашинд юм бүхэн сүнстэй хэмээхийн дээр хүн бол нэг ч биш, бүр гурван сүнстэй байдаг хэмээн номлодог. Энэ тухай Б.Ринчен академич "Хүн тус бүрдээ нэг л сүнстэй байдаггүй. Хүнд гурван сүнс байдаг. Үүний хоёр нь үхдэг сүнс, нэг нь үхдэггүй сүнс байдаг.

Тэгэхлээр эдгээр гурван сүнс буюу гурван эзэн нь бөөгийн шашны үүднээс бол эхийн талаас олж авдаг мах, цусны сүнс буюу эзэн, эцгийн талаас олж авдаг ясны сүнс буюу эзэн, гурав дахь нь тэнгэр сүнс юм. Хүн үхэхэд мах цусны сүнс нь хүний биед гурван жил болдог, өөрөөр хэлбэл, тэр хүний бие бүрэн эвдэрч үгүй болтол байж л байдаг. Ясны сүнс нь ясанд, тэгэхдээ сүүжний ясанд байдаг. Сүүжний яс хэдийд алга болно тэгэхэд л хамт үгүй болдог гэж үздэг. Эцэст нь хэлэхэд тэнгэр сүнс нь яс махны сүнсүүд алга болоход энэ сүнс дэгдээд алга болчихдог юм хэмээн үздэг² гэжээ.

Бөөгийн шашинд хүнийг ийнхүү гурван төрлийн сүнснээс бүрдэх бөгөөд ясны сүнс буюу бодис, мах, цусны сүнс буюу эрчим хүч нь тухайн хүнийг үхмэгц тодорхой хугацааны дараа үгүй болдог, өөрөөр хэлбэл, өөр

¹ Гэхдээ бөөгийн шашин энэ асуудалд анхаарал хандуулдаггүй гэсэн хэрэг огт биш. Энэ хорвоод амьдраад, нас барсан хүний сүнс эргээд хүний биед орж төрдөг эсэх, төрөхдөө хэрхэн сүнс нь шилждэг тухай Монголын Нууц Товчоонд гардаг Алунгуа эхийн домогт илэрхий өгүүлдэг бөлгөө. Мөн энд тэмдэглэхэд, бөөгийн шашны сүнс шилжих тухай үзэл нь бурханы шашны хойт нас, дахин төрөх тухай сургаалтай төстэйн дээр мөн тодорхой ялгаатай юм.

² Пүрэв О. Монгол бөөгийн шашин. УБ., 1999. 125 дах тал. Жич:[Б.Ринчен профессор тэнгэрийн сүнс гэж нэрлэснийг судлаач О.Пүрэв дээрх бүтээлдээ сэтгэл оюуны буюу амин сүнс хэмээн тодруулан тайлбарлажээ. Нэр томъёоны хувьд ялгаатай боловч эдгээр нь нэг л утга санааг илэрхийлнэ].

хэлбэрт хувирдаг, харин *тэнгэрийн сүнс* буюу мэдээлэл бол мөнх оршино хэмээн үздэг ажээ.

Хүн бол бодис /буюу матери/, эрчим /буюу энерги/, мэдээлэл /буюу информации/ гурвын нэгдэл, цогц тогтолцоо бөгөөд “бусад бүх организмын адил орчинтойгоо бодис, эрчим, мэдээлэл байнга солилцож (хооллох, амьсгалах, дулаан солилцох, ялгаруулах, өсөн үржих, танин мэдэхүй, хэрэглээний болон оюуны үнэт зүйлсийг бүтээх, харилцах г.м.) байдаг, биеийн болоод оюуны оршихуй бүхий нэгэн төрлийн өөрөө эмхрэн зохион байгуулагддаг сарнимхай тогтолцоо мөн”¹. Дээрх солилцоо нь синергетикт илэрхийлж буй нэр томъёогоор бол тогтолцооны гадаад орчин болон дотоод элементүүд хоорондын бодис, эрчим, мэдээллийн байнгын, гурвал солилцоо байдаг.

Бодис, эрчим, мэдээлэл нь нэгээс нөгөөдөө харилцан шилждэг. Бодис ба энерги бол биежиж хувирсан мэдээлэл гэсэн үг. Энэ бүхэн бол ертөнц дээр энерги цоо шинээр үүсдэггүй, бас устдаггүй, харин байнга харилцан шилжиж, өөрчлөгдөн, хэлбэрээ өөрчилж байдаг, динамик үйлийн үр байдаг гэсэн термодинамикийн хуультай холбоотой. Ертөнц өөрөө ч гэсэн үүсээгүй, бас устахгүй. Ертөнц нь өөрөө мөн л бодис, эрчим, мэдээллийн тодорхой биеэ даасан төлөв бөгөөд үзэгдэл, юмс өөрөө, аяндаа эмх замбараагүй доод бүрэлдлээс улам дээшлэн дээд эрэмбэнд хүрч цэгцрэн боловсордог, улмаар цагаа болохоор өөрөө, хар аяндаа эвдэрч, шатлан задардаг (деиерархизаци) тухай синергетикийн хуулиуд манай ертөнцөд түгээмэл байдлаар үйлчилдэг. Бүх юм үзэгдэл фрактал бүтэцтэй тул энэ бол түгээмэл шинжтэй хууль. Тиймээс ч фрактал бүтэцтэй ертөнцийг танин мэдэхэд синергетикийн хамгийн их давуу тал оршино хэмээн хэлж болно.

Философийн түүхийн харьцуулсан судалгааны зэрэгцүүлэн судлах хэв маяг буюу түүхэн философийн (историко-философский) параллелизм гэж байдаг. Философийн түүхийн судалгааны энэ хэв маягийн үүднээс логик-культурологийн буюу учирзүй-соёл судлалын байр суурьнаас хандвал эртний сэтгэгчдийн дөрвөн махбодын онол ба орчин үеийн физик дэх таталцлалын, цахилгаан соронзон орон, сул харилцан үйлчлэлийн орон, хүчтэй харилцан үйлчлэлийн орнуудын онолыг болон эртний монголчуудын гурвал сэтгэлгээний уламжлал, ардын аман зохиол дахь ертөнцийн гурвын

¹ Бранский В.П. Теоретические основания социальной синергетики// Вопросы философии. 2000. №4. с. 115.

тухай сургаал, бөөгийн шашин болон бурханы шашин дахь гурван ертөнцийн тухай сургаал ба ертөнцийн бүх юмс бодис, эрчим, онч дохио гурвын нэгдэл болох талаархи орчин үеийн синергетик онолын үзэл санаа зэргийг харьцуулан үзэж болно.

Байгалийн шинжлэх ухаан үүслийн үеэсээ л ертөнцийн хамгийн жижиг хэсэг болох анхдагч материйг олохыг оролдож ирсэн ба үүнд физикийн шинжлэхүй ухаан буюу бодисын зүй гэж монголчуудын нэрлэж, орчуулж байсан ухаан томоохон алхмууд хийсэн байна. Сүүлийн үед, ялангуяа физикч эрдэмтдийн өмнө Ороны Нэгдсэн Онол байгуулах зорилт чухлаар тавигдаж буй нь ерөөс сонгодог биш шинжлэх ухааны дараах үеийн үндсэн онцлог болж байна. Ороны Нэгдсэн Онол боловсруулан, ололт амжилт дээр нь тулгуурласан шинэ технологи сэтгэгдэшгүй биш гэхэд илэрхийлэх үг ойлголтууд нь үүсэн буй болоогүй байгаа олон шинэ зүйл буй болгох болно. Цахилгаан соронзон орны шинж чанар, харилцан үйлчлэлийн зүйтогтол дээр үндэслэн электроник буй болсон бол мэдлэг гүнзгийрэхийн хирээр позитроник, нейтроник гэх зэрэг мэдээллийн технологийн шинэ салбар үүсэх болно. Үүнтэй холбогдон дэлхийн бараг бүх шашинд байдаг “*тэнгэр бурхан*”-ы тухай ойлголтод эрдэмтэд шинэ өнцгөөс, шинэ үнэлэмжийн баримжаатайгаар хандах шаардлага үүссэн байна.

Эртний Грекийн философич Демокрит бүх юмс хуваагдашгүй жижиг хэсэг болох атомуудаас бүрдэх ба атом нь хүнд, маш удаан хөдөлгөөнтэйгээс эхлээд маш хөнгөн, хурдан хөдөлгөөнтэй галт атом хүртэл маш олон янз гэж үзэж байлаа. Үүнээс өмнө Эмпедокл *шороо, ус, хий, гал* хэмээх язгуур дөрвөн махбодоос ертөнц бүрдэнэ гэж үзэж байжээ. Шашин судлаачид 8000 жилийн түүхтэй гэж үздэг эртний сүсэг бишрэл, түүний хамгийн өндөр түвшинд хүртлээ хөгжсөн, үүнийхээ улмаас ч НТ-ын 16-р зуун хүртэл Монголчуудын давамгайлах шинжтэй сүсэг бишрэл байсан, өнөө үед ч эрчимтэй сэргэж байгаа бөөгийн шашны философийг буюу гүн ухааныг эртний дэлхий дахины философи, орчлон ертөнц төвт үзэлтэй харьцуулан үзэж судлах оролдлого хийхийг санаархсан болно. Эртний Грекийн философич Платогийн сургаалд *Эйдосын* тухай асуудал чухал байр эзэлдэг. Эйдос бол хүний ертөнцөөс ангид боловч түүнтэй салшгүй холбоотой нэгэн төрлийн ертөнц байдаг. Хүний сүнс эйдосын ертөнцөд байхдаа бүхнийг мэдэж байдаг боловч хүний дунд /буюу хүний ертөнцөд/ төрмөгцөө, түүний алдарт ёгтлолоор бол *агуйд* байгаа хүмүүс тэр бүхнээ мартаж орхидог.

Тэгээд хүний танин мэдэхүй бол эйдосын ертөнцөд байхдаа мэддэг байсан бүхнээ эргүүлэн сэргээн санах үйл ажиллагаа бөгөөд "хэрэв суралцах гэдэг нь сэргээн санахуй юм бол сүнс үхэлгүй мөнх байх ёстой"¹ хэмээн Плато үзсэн. Платогийн нэрлэснээр Эйдосын ертөнцийг Монгол бөөгийн дуудлагад сүнс буюу онгодууд үхэлгүй, мөнх оршигч *харанхуй орон* хэмээн нэрлэдэг байна.

Бөөгийн шашинд *нартын орон, харанхуйн орон* хэмээх хоёр орныг ялган үздэг. "Нарт хорвоо" гэгч нь хүмүүс бидний оршин байгаа ертөнцийн гурван тив буюу өөрөөр хэлбэл манай ертөнц дэх зөвхөн энэ насныхаа өдөр тутмын амьдралын аахар шаахар зүйлээс өөр зүйлийг боддоггүй хүмүүсийг хэлж байхад "харанхуйн орон" гэгч нь хүмүүс нарт хорвоогоос халиад сүнс нь очдог "орон" юм гэсэн ойлголт² болно. Харанхуйн оронд очсон сүнс бүхнийг мэддэг. Харанхуйн орон бол цул мэдээллийн орон. Тэрхүү мэдээллийн орон буюу харанхуйн оронд оршиж буй сүнстэй холбоо тогтоох увидас, чадвартай хүнийг бөөгийн шашинд заарин, удган хэмээн нэрлэдэг. Харин Плато тийм хүнийг *философич* гэж нэрлэж байв. Орчин үед эрдэмтэд *хүн төрөлхтний мэдээллийн сан, ноосфер ертөнцийн мэдээллийн нэгдсэн орон* хэмээн нэрлэж байгаа ийм ямар нэгэн "орчин", "орон" байдаг болох нь бөөгийн шашинд ч, бурханы шашинд ч, бусад бараг бүхий л шашны сургаалуудад илэрхий агуулагдсаар иржээ гэж үзэж байна. Харин соёл, хэл, ёс заншлаасаа хамааран янз бүрээр нэрлэж байснаараа л ялгаатай болохыг, тухайлбал, Платогийн эйдосын тухай сургаалаас бэлхнээ харж болно.

Энэхүү "Х орон" бол цэвэр мэдээллийн хуралдал, мэдээллийн орон болно. Мэдээлэл гэдэг бол хувирсан бодис ба эрчим мөн. Бөөгийн шашны үүднээс тэнгэр сүнс нь яс махны сүнсүүд алга болоход дэгдээд алга болчихдог хэмээн үздэг нь ертөнц дээрх бодис ба эрчим тодорхой нөхцөлд мэдээлэл болон хувирч, улмаар энэхүү мэдээллийн хэсэг нь "харанхуйн орон"-д, өөрөөр хэлбэл, "мэдээллийн сан"-д очиж нэгддэг, тэнд хөгжил үргэлжилсээр байдаг гэсэн хэрэг мөн. Өөрөөр хэлбэл, хөгжил "энэ ертөнцөд" тасарч буй мэт боловч үнэн хэрэг дээрээ /буддын философийн тасархай үгүй, мөнх үгүй хэмээх зарчимтай адил/ "өөр ертөнцөд" үргэлжилж байдаг, тэр "өөр ертөнц" бол сүнс орших мөнхийн ертөнц болно. Хөгжил

¹ Платоны философийн тайлбар. /орч. Б.Даш-Ёндон/. УБ., 1998. 43 дах тал.

² Пүрэв О. Монгол бөөгийн шашин. УБ., 1999. 111 дэх тал.

ийнхүү "өөр ертөнцөд", өөр хавтгайд шилжих үйл явц бол хөгжлийн тухай синергетик үзэл баримтлалын нэгээхэн хэсэг болно.

Тогтолцооны хөгжил ийнхүү өөр хавтгайд үргэлжлэх гол шалтгаан бол тухайн тогтолцоо өөрийн макродифференциалаа алдсантай холбогддог. Аливаа тогтолцоо, бүтэц өөрийнхөө шинж чанарыг агуулсан хамгийн бага хэсэг болох макродифференциальтай [Хегелийн үзлээр бол "самость" гэж нэрлэдэг тийм зүйл] байх ёстой бөгөөд энэ нь хамаг юмс хийгээд үзэгдлийн хөгжих, хувьсах үйлийн үрд заавал фрактал бүтэц үүсдэгтэй холбоотой байдаг. Макродифференциаль гэдгийг хамгийн энгийнээр ойлговол тухайн юмс ба үзэгдлийн хөгжлийн "тэр юм байх" нөхцөл, хүрээний хязгаарыг хэлнэ. Энэ хууль бүх үзэгдэлд үйлчилнэ. Жишээ нь, хөгжим бол мөн чанараараа зүгээр л чимээ, эсвэл шуугиан мэт долгион гэж хэлж болох бөгөөд хүнийг маш том хонхон дотор суулгаад гаднаас нь цохиж шийтгэдэг (амийг нь хороодог) эрүү шүүлт байсан тухай домог яриа, аман мэдээ байдаг. Бас хүнийг ямар ч чимээ, шуугиан, хөгжимгүй тасалгаанд удаан байлгавал мөн л ямар үр дүн гарах нь тодорхой.

Гэтэл нөгөө талаас, хөгжим бол хүний сэтгэлийг хөглөж, аз жаргал, эрч хүч өгдөг бөгөөд оюун ухааныг хөгжүүлэх, эрүүл мэндийг хамгаалах болоод өвчнийг эмчлэх маш хүчтэй эм болдог асар их эрчимлэг, мэдээллэг зүйл мөн. Монголчууд бол Морин хуур, уртын дуу хоёроороо зөвхөн хүний төдийгүй, мөн адгуусан амьтны сэтгэлийг уярааж, нулимсыг нь дуслуулж чаддаг гайхамшигтай ард түмэн. Учир нь Монголчууд хөгжмийн макродифференциаль ямар байдгийг нарийн мэддэг, мэдэрч чаддаг хүмүүс юм. Энэ нөхцөл алдагдмагц хөгжим хор болдог. Гэхдээ бидний /хүний/ сонсож чаддаг хэлбэлзэл, давтамжийн хүрээнд гэсэн үг. Хүний сонсож чадахгүй /буюу хүнд аюултай/ хэт нам, эсвэл хэт өндөр давтамж, хэлбэлзэлтэй хөгжмийн долгион нь тухайн хүрээ, тухайн орон зай, орчиндоо бол макродифференциаль нь өөр байх боломжтой бөгөөд энэ бол тогтолцооны хөгжил өөр хавтгайд үргэлжилж байгаа хэрэг.

Хүн бол нэг талаас ертөнцийн макродифференциаль, харин хүний макродифференциаль бол түүнийг амьд байлгаж байдаг бодисон буюу ясан бие, эрчимэн буюу махан, цусан, шөрмөсөн бие, эцэст нь мэдээллэн буюу оюун санаа, сэтгэлийн биеийн хослол, зохирол болно. Ямар нэгэн бүрэн бүтэн араг яс болоод мах, цус бүхий цогцос, мөн хэн нэгний сүнс байлаа гээд энэ нь тухайн хүнийг бүтээн бий болгож чадахгүй, тухайн хүн "өөрөө"

байхын тулд тэдгээрийн зохирол маш чухал. Амьд бүхний генийг бүрдүүлдэг бодис бол тавхан төрлийн амин хүчил бөгөөд тэдгээрийн янз бүрийн хослолыг агуулсан гинжин хэлхээс болох DNA-д л хамаг учир байдгийг бид мэднэ. Бүрдүүлж байгаа элементүүдийнхээ химийн найрлага, тоо хэмжээ зэргээрээ адил боловч тэдгээрийн холбоос, зохицлоороо ялгаатай учраас л бүхэл тогтолцооны шинж, чанараараа ч эрс өөр болдог бал чулуу, алмаас эрдэнэ хоёрыг ч үүний жишээ болгож болно.

Бөөгийн шашны дээрх үзэл нь хүн өөрийн макродифференциалиа алдах үйл явцыг илэрхийлсэн хэрэг. Улмаар тухайн хүн макродифференциалиа алдсанаар түүнийг бүрдүүлж байсан бодис, эрчим, мэдээлэл нь хувьсан нэгдэж "хүн төрөлхтний мэдээллийн сан" буюу "харанхуйн орон"-той эвсэн нэгдэж, тэнд хөгжлөө үргэлжлүүлдэг аж. "Харанхуйн орон" ч хөгжил маш нарийн төвөгтэй бөгөөд сүнс шилжих, төөрөх зэрэг олон үйл явц өрнөдөг болохыг бөөгийн шашны гүн ухааны үзлээс харж болно.

Бөө нар бол "нартын орон"-д сууж байгаа хүмүүс, харин сүнс, онгод бол "харанхуйн орон"-д байгаа мэдээлэл. Тэгэхээр бөөлнө гэдэг бол "нарт ертөнц", "харанхуй ертөнц" хоёрын хоорондох орон цагийн зөрөөг гатлан давж /үнэн хэрэгтээ тэр ертөнц тийм ч хол биш, харин бидний зэргэлдээ ертөнц "parallel universe" юм/, энэ хоёр ертөнцийг холбох үйл ажиллагаа мөн гэж хэлж болно. Ингэж хэлэх бололцоог ертөнцийн аливаа үзэгдэл хийгээд юмс цөм шугаман биш хуулиар хөгждөг, түүний дотор цаг хугацаа, орон зай ч ялгаагүй шугаман биш, олон хэмжээст хаос төрхтэй болохыг олж нээсэн сонгодог биш шинжлэх ухааны дараах үеийн сэтгэлгээний шинэ хэв маяг болох синергетик өгч байна.

"Аливаа эсрэг тэсрэг биежил бол тэдгээрийн "тэрсч, найрч" бүрэлдсэн бүтэн "1" чанарын хязгаарт илрэх туйл юм. Зургаас харвал хар, цагаан хоёр "туйлд" хүртэл өнгө тасралтгүй, бас төгсгөлгүй шилжинэ. Энэ бол зөвхөн өнгөнд бус, бүхий л үзэгдэл юмст бүрэлдэх чанар мөн. Энэ хоршил зүй байгаль, нийгэм, сэтгэл зүй, үзэл номнол хийгээд аливаа үзэгдэл хувиралд



түгээмэл тохионо”¹. Дээр өгүүлснээр “харанхуйн орон” ба “нарт орон” нь бие биетэйгээ эсрэгцсэн, хоёр тусдаа “орон” биш, харин ч нэгэн нэгдмэл зүйлийн хоёр хязгаар болохыг доорх зураг хийгээд тайлбараас харж болно.

Энэ хорвоо ертөнц бол нэгдмэл зүйл, түүнийг бүрдүүлэгч хэсгүүд нь бодис, эрчим, мэдээлэл гурав бөгөөд эдгээр нь нэг юмны л өөр өөр хэлбэр, өөр өөр шинж бүхий талууд болно. Бөө бол энэ зүй тогтлыг шууд мэдэрч, улмаар эдгээр “орон”-уудын хооронд чөлөөтэй шилжилт хийж чаддаг, чөлөөтэй холбоо харилцаа тогтоож чаддаг увидастангууд ажээ. Өөрөөр хэлбэл, газар эх буюу материаллаг ертөнц /энэ бол ертөнцийн эм үүтгэл буюу арга тал/ ба тэнгэр эцэг буюу мэдээллийн ертөнц /энэ бол ертөнцийн эр үүтгэл буюу билиг тал/ хоёрыг холбогч, тэдгээрийн амьд нэгдлийг шууд мэдрэгч, хэрэгжүүлэгчид хэмээн ойлгож болох юм.

Бөөгийн онгод ороход тухайн хүн өөрийн ухамсарт байдлаа алдаж “өөрөө биш” болдог. Учир нь бөө хүний сүнсний оронд ертөнцийн мэдээллийн оронд оршиж байсан сүнс болох онгод орж, зөвхөн бие, махбодыг нь ашиглан мэдээлэл дамжуулдаг. Энэ тухай бөө судлаач О.Пүрэв: “ямар нэгэн бөөгийн оюун санаанаас ангид, гурваас дээш жилийн өмнө өөд болсон өөр нэгэн бөөгийн оюун санаа түүний биед шингэж, уураг тархины нь эс эдүүдэд ямар нэгэн өөрчлөлт оруулан, хэл авиагаар нь дамжуулан үзэл бодлоо илэрхийлэн, намтар дурсамжаа ярихыг бөөд онгод орлоо хэмээн үздэг”² гэж тайлбарлажээ. Мөн “онгод бөөгийн биед орж ирэхэд бөө хүн гэрийн гадна юу болж буй, өөрөө ямар үйлдэл хөдөлгөөн хийж байгаагаа сайн мэддэггүй. Гагцхүү онгодтойгоо л харилцаж, хэлсэн ярьсныг нь дамжуулан хэлж, дуулж байдаг”³ хэмээн нэгэн удганы ярьсныг саахь эрдэмтэн тэмдэглэн авчээ. Тэгэхээр бөө бол дээд тэнгэр буюу “мэдээллийн орон”-ы “зарц”, түүний “нарт ертөнц”-тэй харилцах “хэрэгсэл” /гар утас нь/ болно.

Гэхдээ зөвхөн заарин, удгад л ийм чадвартай биш бөгөөд хүн бүхэнд ийм чадвар байдаг. Энгийн хүмүүс тэнгэртэй байнга холбоотой байдгаа мэдэрч чаддаггүй, ийм мэдрэмж нь сул байдаг. Jeffrey Wands, Tom Philbin нар *The Psychic in You: Understand and Harness your Psychic Power*(2004) хэмээх номондоо “Бид бүгдээрээ төрөлхийн психик чадвартай, энэ чадвар

¹ Лхагва О., Сайнсаа Ц., Эрдэнэтуяа Л., Квант физик ба дорнын сэтгэлгээ// Манай Монгол. 2004. №4. 36 дах тал

² Пүрэв О. Монгол бөөгийн шашин. УБ., 1999. 148 дах тал.

³ Мөн тэнд. 144-145 дах тал.

бидний амьдралд цаг үргэлж илрэн гарч байдаг. Психик үйл явц бол энгийн сэтгэн бодох үйл ажиллагааг хэрэглэхгүйгээр мэдээлэл хүлээн авах явдал юм. Энэ мэдээлэл бол бидэнд ухамсарлагдсан ба үл ухамсарлагдсан мэдрэхүйгээр дамжин хүрдэг дотоод сэтгэлийн эрчимд агуулагдаж байдаг". Мөн "нас барагсад бидэн рүү телепатаар харилцдаг бөгөөд энэ бол тэдний сүнсэнд байгаа эрчимийн багц болон бодол санаа бидэнд дамжуулагдаж буй хэрэг мөн. Бидний тархин дахь психик механизм болох зургаа дахь мэдрэхүй ийм дохиог яг л радио хүлээн авагч мэт хүлээн авч, уг мэдээг бидэнд ойлгомжтой болгон орчуулдаг"¹ хэмээн бичжээ. Харин бөөгийн шашинд үүнийг "харсан тэнгэрийнхээ нөлөөллийг зөн билгээрээ хүлээн авах чадвар"² хэмээн нэрлэдэг. Орчлонт хорвоо хийгээд хүний үйл ажиллагааг зохицуулан чиглүүлж, хорвоогийн бүх хүнийг нэгбүрчилэн харж, түүнийг сахин манаж байдаг "Хий ухаар юм"-ыг харсан тэнгэр гэж үздэг,³ өөрөөр хэлбэл, бидний амьдрал ахуйд байнга нөлөөлж, бидэнд мэдрэгдэж байдаг мэдээллийн орон юм.

Энэ тухай бөөгийн дуудлагад:

"...үе сольж үндэс болтол
үргэлжийн цагаан мөрөө хайрла та
хараатай нартыг тэвчиглүүлээ би
харсан тэнгэрийг шүтлээ..." гэж байдаг ажээ⁴.

Харсан тэнгэрээ мэдрэх чадвар өндөртэй хүмүүс л бөө болдог бөгөөд тэд харсан тэнгэрээ мэдрэх төдийгүй, түүнтэй харилцдаг. Гадаад орчин болон сансар, огторгуйгаас, бидний зэргэлдээ ертөнцөөс хүн хийгээд амьтанд төрөл бүрийн мэдээлэл, дохиолол байнга ирж байдаг. Тэр нь хүн болон амьтдын амьдрал, эрүүл мэнд зэрэгт нөлөөлж байдаг нь аливаа тогтолцоо байнга бодис, эрчим, мэдээллийн харилцан холбоо, харилцан солилцооны үндсэн дээр оршин тогтнодог зүй тогтлын илрэл юм. Хүн бүр өөрт нь гадаад орчноос ирж байгаа бүх мэдээллийг хүлээж авдаг боловч тийнхүү хүлээн авч байгаагаа мэдэрч чаддаггүй /яг л сүлжээ хүлээн авах чадвар султай гар утас шиг/ учраас амьдралд нь янз бүрийн саад тотгор учирдаг, гэнэтийн аюулд өртдөг, өөрөөр хэлбэл, нүдтэй боловч сохор гэсэн үг. Нийгмийн хийгээд соёлын хөгжил ба сүйрэл/катастроф/, мөн бусад макро

¹ Can you communicate with dead loved ones?// URL: <http://msnbc.msn.com/id/10618386>

² Пүрэв О. Монгол бөөгийн шашин. УБ., 1999 103 дах тал

³ Мөн тэнд. 99-100 дах тал

⁴ Мөн тэнд.

төвшний асуудлууд, үзэгдлүүдийг /гэхдээ зөвхөн энэ биш/ бөөгийн шашны гүн ухааны үүднээс оновчтой тайлбарлаж, тодорхойлж, улмаар танин мэдэж, түүнийхээ үндсэн дээр нийгэм-соёлын хөгжлийн үйл явцын ирээдүйн төлөвийг урьдчилан харж, тооцоолох боломжтой юм. Ерөөс хүн, түүний амьдрах орчины тухай бүхий л шинжлэх ухааны адилаар синергетикийн гол зорилго, үүрэг нь бөөгийн шашны сэтгэлгээний нэгэн адил ирээдүйг урьдчилан харах, тогтолцооны хөгжлийг урьдчилан тааварлах, гипотези дэвшүүлэх явдал байдгаараа эдгээр эрс өөр соёлын бүтээгдэхүүнүүд ижилсэх талуудтай юм. Нэгдмэл орчлонг танин мэдэх нь нэгдмэл арга зүйн хувьд л бололцоотой бөгөөд ийм түгээмэл аргыг боловсруулахын тулд дорны, түүний дотор Монголчуудын сэтгэлгээний онцлогийг харгалзах нь зайлшгүй тул орчлон ертөнц нэгдмэл болохыг аль эртнээс дуудлага номондоо дуулсаар ирсэн Монгол бөөгийн шашны сэтгэлгээний ололтыг судлах нь маш чухал.

Профессор О.Лхагва нэгэнтээ: “Тэнгэр хийгээд их талтай тулан амьдарч байсны хувьд монгол туургатны танихуйн үзэл, үнэмшил нь дорны сэтгэлгээ, танин мэдэхүйн нэг өвөрмөц чиглэл байдлаар хөгжсөн нь мэдээж. ... Суурин ард түмнээс гоц ялгаатай нь Монголчууд алга дарам газарт “зав чөлөөгүй” хадагдаагүй, хөлгүй тэнгэрийн доорх “хязгааргүй” талд байгалийн эрхшээлд сөгдөж, аргадаж амьдрахдаа түүн лүгээ нэгсэхүйн увьдисыг олсон байх илүү магадлалтай”¹ хэмээн бичсэн нь Монголчуудын ертөнцийг танин мэдэх арга, арга зүй нь хүн төрөлхтний танин мэдэхүйд өөрийн гэсэн байр суурь, үүрэгтэй болохыг илэрхийлсэн хэрэг биз. Монгол хэмээх үгээр тэмдэглэн илэрхийлж буй уудам нутаг дэвсгэр дээр олон зууны турш түүх, соёлоо дээдэлж ирсэн уламжлалтай ард түмний гүн ухаанжсан түүхийг бичих нь үндэстний өөрийгөө танин мэдэх, уламжлалаа хадгалах төдийгүй баяжуулан сэргэн мандах үйл явцад шинэ эрч хүч өгөх болно.

Амьдралын бодит ахуйн нарийн нийлмэл үйл явцыг шинэ үзэл санаа, онол аргазүй, үг ойлголт хэрэглэн хандах нь өдөр тутмын амьдралын үйл явцыг шинээр харах, тайлбарлах, тулгамдсан асуудлуудыг шинэлэг зохистой үр дүнтэй шийдвэрлэх бололцоо олгоно. Би-г хүрээлэн байгаа би-гийн төлөвшил хөгжилд хамгийн их нөлөөг шууд үзүүлж байдаг бодит байдлын хэсэг бол соёлын оршин тогтнох орон зай, хэрэгсэл болох хэл мөн.

¹ Лхагва О., Сайнсаа Ц., Эрдэнэтуяа Л. Квант физик ба дорнын сэтгэлгээ// Манай Монгол. 2004. №4. 39 дэх тал

Ашигласан материал

1. Бранский В.П. Теоретические основания социальной синергетики// Вопросы философии. 2000. №4. с. 112-129.
2. Князева Е.Н. Синергетический вызов культуре// www.synergetic.ru
3. Князева Е.Н., Туробов А. Единая наука о единой природе// www.portalus.info
4. Лхагва О., Сайнсаа Ц., Эрдэнэтуяа Л. Квант физик ба дорнын сэтгэлгээ// Манай Монгол. 2004. №4.
5. Платоны философийн тайлбар. /орч. Б.Даш-Ёндон/. УБ., 1998.
6. Пүрэв О. Монгол бөөгийн шашин. УБ., 1998.
7. Пүрэв О. Монгол бөөгийн шашин. УБ., 1999.
8. Степин В.С. Саморазвивающиеся системы и постнеклассическая рациональность// Вопросы философии. 2003. №8.
9. Сүхбат Ш. Монгол нүүдэлчин ардын шашин шүтлэгийн зан үйл. УБ., 2005.
10. Чулуунжав Д. Монголын түүхийн философи. УБ., 2005.
11. Can you communicate with dead loved ones?// <http://msnbc.msn.com>